



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011 0251, Факс: (976) 7011 2460,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2016.10.11 № 01/7034
танай 2016-10-06 ны № 251/600-Т

ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН
ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ЗАХИРАЛ Ё.НЯМЖАВ ТАНАА

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газрын үйл ажиллагаа хариуцсан Дэд захирлаар томилогдохоор нэр дэвшсэн Дэлэг-Очирын Хулганажав, үйлчилгээ чанар хариуцсан Дэд захирлаар томилогдохоор нэр дэвшсэн Дондоогийн Чулуунбаатар, Санхүү, эдийн засгийн хэлтсийн даргаар томилогдохоор нэр дэвшсэн Сүхбаатарын Солонго нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нар нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуулийн 11, 12 дугаар зүйлд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР



Х.ЭНХЖАРГАЛ

015750